

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах,
маягт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Шалгалтын бүрэлдэхүүн, агуулга, хэлбэр, үнэлгээ”-ний маягтыг хавсралтаар баталсугай.

2.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-ын 3.3 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

1/“3.3 дахь хэсэгт:

3.3.2.цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэн дүрэмт хувцас өмссөн үед далдлагдах шивээстэй бол эрүүл мэндээр тэнцсэнд тооцно;”.

3.Мөн даргын 2023 оны А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-ын 3.1.2 дахь заалтын “инженер” гэсний дараа “их өгөгдөл, дата аналитик, хиймэл оюун ухаан,” гэж, 3.2.4 дэх заалтын “ур чадвартай,” гэсний дараа “цэргийн жинхэнэ алба биеэр хаасан,” гэж, 3.5.8 дахь заалтын “байгууллагаас” гэсний дараа (Эрүүгийн цагдаагийн алба, Хар тамхитай тэмцэх газар гэх мэт)” гэж, 5.2 дахь хэсгийн “дарааллаар эрэмбэлнэ.” гэсний дараа “Шалгалтын бүрэлдэхүүн, агуулга, хэлбэр, үнэлгээний маягт (Хавсралт №4)” гэж тус тус нэмсүгэй.

4.Мөн даргын 2023 оны А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-ын 3.1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/“3.1 дэх хэсэг:

3.1.3.цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас халагдаж, чөлөөлөгдөөд эргэж орох хүсэлт гаргасан иргэн нь 40 хүртэлх насны байна.”.

5.Мөн даргын 2023 оны А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-ын 3.4.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/“3.4 дэх хэсэг:

3.4.2.дүрэмт хувцас өмссөн үед далдлагдсан шивээстэй бол өгүүлэмж (хүчирхийлэл, садар самуун, хар тамхи, мансууруулах бодис зэргийг сурталчилж, илэрхийлээгүй байх)-ийг харж, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ;”.

6.Мөн даргын 2023 оны А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-ын 2.5, 2.6, 2.7, 2.8 дахь хэсгийн дугаарыг “2.4, 2.5, 2.6, 2.7” гэж, 3.3.2, 3.3.3 дахь заалтын дугаарыг “3.3.3, 3.3.4” гэж, 3.3.1 дэх заалтын “Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан” гэснийг “Засгийн газрын 2024 оны 140 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан” гэж, 4.2.4 дэх заалтын “боловсролын үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар” гэснийг “боловсролын үнэмлэх, төрийн мэдээллийн цахим сангаас авсан лавлагаа,” гэж тус тус өөрчилсүгэй.

7.Мөн даргын 2023 оны А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн иргэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тооцох журам”-ын 2.4 дэх хэсгийг, 4.2.3 дахь заалтын “, түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар” гэснийг тус тус хассугай.

8.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга (цагдаагийн хурандаа С.Тайван)-д даалгасугай.

9.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Т.СҮХБОЛД

Цагдаагийн ерөнхий газрын
даргын оны дугаар сарын-ны
өдрийн дугаар тушаалын
хавсралт

ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, АГУУЛГА, ХЭЛБЭР, ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

Д/д	Шалгалт	Оноо	Шалгалтын эрх
Нэг.Дунд офицерын албан тушаалын сул орон тоонд өрсөлдөж байгаа иргэн			
1	Хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн талаарх мэдлэг	20	Нийт 40 онооноос 24 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
2	Монгол Улсын түүх соёл, нийгэм, эдийн засгийн талаарх мэдлэг	10	
3	Цахим орчин, компьютерын хэрэглээний программ ашиглах талаарх мэдлэг	10	
4	Монгол хэл, бичгийн чадварын шалгалтад кирилл бичиг, үндэсний бичгийн талаарх мэдлэг болон чадвар	20	Нийт 20 онооноос 12 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
5	Дүн шинжилгээ хийх чадвар (сэтгэхүйн чадамж)	20	Нийт 20 онооноос 12 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
6	“Эссэ бичлэг” чадвар	10	Нийт 10 онооноос 6 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
7	Бие бялдар сорил	10	Нийт 10 онооноос 7 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
8	Эрүүл мэндийн үзлэг		Тэнцэнэ, тэнцэхгүй дүгнэлт гарна.
Хоёр.Ахлагч албан тушаалын сул орон тоонд өрсөлдөж байгаа иргэн			
1	Хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн талаарх мэдлэг	10	Нийт 40 онооноос 24 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
2	Монгол Улсын түүх соёл, нийгэм, эдийн засгийн талаарх мэдлэг	20	
3	Цахим орчин, компьютерын хэрэглээний программ ашиглах талаарх мэдлэг	10	
4	Монгол хэл, бичгийн чадварын шалгалтад кирилл бичиг, үндэсний бичгийн талаарх мэдлэг болон чадвар	20	Нийт 20 онооноос 12 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
5	Дүн шинжилгээ хийх чадвар (сэтгэхүйн чадамж)	20	Нийт 20 онооноос 12 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.

6	“Эссэ бичлэг” чадвар	10	Нийт 10 онооноос 6 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
7	Бие бялдар сорил	10	Нийт 10 онооноос 7 ба түүнээс дээш оноо авсан оролцогч дараагийн шалгалтад оролцох эрхтэй.
8	Эрүүл мэндийн үзлэг		Тэнцэнэ, тэнцэхгүй дүгнэлт гарна.

Тайлбар: Нийт авбал зохих оноо 100 байх бөгөөд 60 ба түүнээс дээш оноо авсан оролцогчийг шалгалтад тэнцсэнд тооцно.

---oOo---